

Биеийн тамир, спортын улсын хорооны даргын  
2024 оны 08 дугаар сарын 05-11-ний өдрүүдэд  
тушаалын хөрдугаар хавсралт

ОЛОН УЛСЫН ХҮҮХДИЙН СПОРТЫН Х НААДМЫН  
НЭГДСЭН ЗААВАР

Нэг. Зорилго

Хөрш орнуудын хамтын ажиллагааг спортоор дамжуулан бэхжүүлэх,  
Монголын үндэсний спорт, ёс заншил уламжлалыг хүүхэд, залуучуудад сурталчлах,  
өвийг түгээн дэлгэрүүлэх, авьяаслаг тамирчдыг нээн илрүүлж, бэлтгэхэд оршино.

Хоёр. Наадмын удирдлага зохион байгуулалт

Наадамд Монгол улс, БНХАУ Өвөр монголын өөртөө засах орон, ОХУ-ын  
Буриад улсын баг тамирчид оролцено.

Наадмыг Олимп, нийтийн биеийн тамир, спортын үндэсний хороо, Засгийн  
газрын тохируулагч агентлаг Биеийн тамир, спортын улсын хороо, наадмын Зохион  
байгуулах хороо, спортын холбоод хамтран зохион байгуулна.

Гурав. Наадмын хугацаа, спортын төрөл, насны хязгаар

3.1. Тэмцээний хуваарь:

Наадам 2024 оны 08 дугаар сарын 05-11-ний өдрүүдэд Монгол Улсын  
нийслэл Улаанбаатар хотод зохион явагдана.

- 08 дугаар сарын 05-06-нд багуудыг хүлээж авах
- 08 дугаар сарын 06-нд наадмын нээлт
- 08 дугаар сарын 07-09-нд тэмцээн
- 08 дугаар сарын 10-нд наадмын хаалт
- 08 дугаар сарын 11-ний өдөр багуудыг үдэж өгөх.

3.2. Оролцогчдын насны хязгаар:

Наадамд 15-16 насны тамирчид оролцено.

3.3. Наадмын тэмцээний заавар, хуваарь:

№	Спортын төрөл	Зай, жин, төрөл, ангилал	Насны хязгаар	Тамирчдын тооны хязгаар
1	Сагсан бөмбөг	Охид, хөвгүүд (Баг тус бүр 12 тамирчин, 2 дасгалжуулагч)	2008.01.01 2009.12.31	Улс бүр охид, хөвгүүд тус бүр 1 баг оролцуулна. Тамирчин- 24 Дасгалжуулагч-2 Шүүгч-1
2	Волейбол	Охид, Хөвгүүд: (Баг тус бүр 12 тамирчин, 2 дасгалжуулагч)	2008.01.01 2009.12.31	Улс бүрээс охид, хөвгүүд тус бүр 1 баг оролцуулна. Тамирчин- 24 Дасгалжуулагч-2 Шүүгч-1

3	Футзал	<p><b>Хөвгүүд:</b> (Баг тус бүр 12 тамирчин, 2 дасгалжуулагч)</p> <p><b>Охид:</b> (Баг тус бүр 12 тамирчин, 2 дасгалжуулагч)</p>	2008.01.01 2009.12.31	Улс бүр 1 баг оролцуулна.  <b>Тамирчин- 24</b> <b>Дасгалжуулагч-4</b> <b>Шүүгч-1</b>
4	Хөнгөн атлетик	<p><b>Охид:</b> 100м, 400м, 1500м, 3000м, уртын харайлт,</p> <p><b>Хөвгүүд:</b> 100м, 400м, 1500м, 5000м, уртын харайлт, (1 тамирчин дээд тал нь 2 зай, төрөлд оролцоно)</p>	2008.01.01 2009.12.31	Зай, төрөл тус бүрд 1 тамирчин оролцоно.  <b>Тамирчин-10</b> <b>Дасгалжуулагч-2</b>  Зай, төрөл тус бүрд 2 хүртэлх тамирчин оролцохыг зөвшөөрнө. <b>Шүүгч-1</b>
5	Жүдо бөх	<p><b>Охид:</b> -40кг, -44кг, -48кг, -52кг, -57, -63кг, -70кг, +70кг</p> <p><b>Хөвгүүд:</b> -50кг, -55кг, -60кг, -66кг, -73кг, -81кг, -90кг, +90кг</p>	2008.01.01 2009.12.31	Жин тус бүрд 1 тамирчин оролцоно. (Монгол Улсын багаас жин тус бүрд 2 тамирчин оролцоно)  <b>Тамирчин-16</b> <b>Дасгалжуулагч-2</b> <b>Шүүгч-1</b> <b>Эмч-1</b>
6	Чөлөөт бөх	<p><b>Охид:</b> 43кг, 46кг, 49кг, 53кг, 57кг, 61кг, 65кг</p> <p><b>Хөвгүүд:</b> 48кг, 51кг, 55кг, 60кг, 65кг, 71кг, 80кг</p>	2008.01.01 2009.12.31	Жин тус бүрд 1 тамирчин оролцоно. (Монгол Улсын багаас жин тус бүрд 2 тамирчин оролцоно)  <b>Тамирчин-14</b> <b>Дасгалжуулагч-2</b> <b>Шүүгч-1</b> <b>Эмч-1</b>
7	Бокс	<p><b>Охид:</b> 48кг, 50кг, 54кг, 57кг,</p> <p><b>Хөвгүүд:</b> 48 кг, 50 кг, 54 кг, 57 кг, 60 кг, 63 кг</p>	2008.01.01 2009.12.31	Жин тус бүрд 1 тамирчин оролцоно. (Монгол Улсын багаас жин тус бүрд 2 тамирчин оролцоно)  <b>Тамирчин 10</b> <b>Дасгалжуулагч-2</b> <b>Шүүгч-1</b> <b>Эмч-1</b>
8	Ширээний теннис	<p><b>Ганцаарчилсан:</b> охид, хөвгүүд</p> <p><b>Баг:</b> охид, хөвгүүд, холимог хос</p>	2008.01.01 2009.12.31	✓ Ганцаарчилсан: охид-1, хөвгүүд-1 ✓ Баг: охид 1, хөвгүүд-1 ✓ Холимог хос: охид 1, хөвгүүд-1  <b>Тамирчин-8</b> <b>Дасгалжуулагч-2</b> <b>Шүүгч-2</b>
9	Байт харваа	<p><b>Ганцаарчилсан /60mx2/:</b> охид, хөвгүүд,</p> <p><b>Баг:</b></p>	2008.01.01 2009.12.31	✓ Ганцаарчилсан: охид-1, хөвгүүд-1  ✓ Баг:

		охид, хөвгүүд, холимог баг.		✓ охид 1, хөвгүүд-1 Холимог хос: охид 1, хөвгүүд-1
				Тамирчин-8 Дасгалжуулагч-2 Шүүгч-1

#### ҮЗҮҮЛЭХ ТОГЛОЛТ

10	Үндэсний бөх	Үндэсний бөхийн барилдаанд оролцох тамирчдаас биеийн хэмжээг авсан байна.	2008.01.01 2009.12.31	Улс бүр 4 тамирчин оролцуулна.  Тамирчин- 4 Дасгалжуулагч-1
11	Үндэсний сурын харваа	Охид, Хөвгүүд:  (Улс бүр 4 тамирчин, 1 дасгалжуулагч)	2008.01.01 2009.12.31	Цуваа харваа: Охид-2, хөвгүүд-2  Тамирчин- 4 Дасгалжуулагч-1

**3.4. Техникийн зөвлөгөөн:**

Тэмцээний зохион байгуулалттай холбоотой нэмэлт мэдээлэл, зохицуулалт, тэмцээний сугалаа зэргийг тэмцээн тус бүрийн өмнө зохион байгуулах техникийн зөвлөгөөнөөр хэлэлцэж шийдвэрлэнэ.

**3.5. Дүгнэх журам:**

Тэмцээний спортын төрөл, зай, жин тус бүрээр дүнг гаргаж “sport.gov.mn” веб цахим сайтад байршуулна.

**3.6. Шагнал урамшуулал:**

Спортын төрөл тус бүрийн эхний 3 байрт шалгарсан баг, тамирчин, дасгалжуулагчдад медаль, өргөмжлөл, дурсгалын зүйлээр тус тус шагнана.

**Дөрөв. Наадамд оролцогчдод тавигдах шаардлага**

**4.1. Санхүүгийн нөхцөл:**

4.1.1. Наадамд оролцох бүх багууд Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотод ирэх, буцах тээвэр, байр, хоолны зардлаа өөрсдөө бүрэн хариуцна.

4.1.2. Байр хоолны зардал өдрийн нэг хүний 70 ам доллар байна.

4.1.3. Улс бүрээс албаны 5 хүн, мэдүүлэгт заасан тооны шүүгчдийн наадмын үеийн байр, хоол, дотоодын тээврийн зардлыг наадмын Зохион байгуулах хороо хариуцна.

**4.2. Эрүүл мэндийн даатгал:**

4.2.1. Наадамд оролцогч багуудын бүх тамирчид, дасгалжуулагчид, шүүгчид эрүүл мэндийн даатгалд заавал даатгуулж, эх хувиар нь авчирсан байна.

4.2.2. Багийн бүрэлдэхүүнд 2 эмчийг багтаасан байх шаардлагатай.

4.2.3. Зохион байгуулах хороонд санал ирүүлсэн тохиолдолд эрүүл мэндийн даатгалд Улаанбаатар хотод даатгуулж болно. Улаанбаатар хотод эрүүл мэндийн даатгалд даатгуулсан тохиолдолд холбогдох зардлыг оролцогч багууд өөрсдөө хариуцна.

4.3. Мэдүүлэг хүлээн авах:

Наадмын оролцогч багууд тамирчид, шүүгчдийн тоон мэдүүлгийг 2024 оны 06 сарын 02-ны өдрийн дотор, нэрэн мэдүүлгийг 2024 оны 07 дугаар сарын 15-ны өдрийн дотор [ig2024@sport.gov.mn](mailto:ig2024@sport.gov.mn) цахим хаягаар ирүүлнэ.

Тав. Холбоо барих утас, хаяг, байршил

Олон улсын хүүхдийн спортын Х наадмын Зохион байгуулах хорооны албан ёсны хаяг:

Шуудангийн хаяг: Монгол Улс, Улаанбаатар – 14201, Сүхбаатар дүүрэг, Бага тойруу-55, Спортын төв ордон, Засгийн газрын тохируулагч агентлаг- Биеийн тамир, спортын улсын хороо

Цахим хаяг: [ig2024@sport.gov.mn](mailto:ig2024@sport.gov.mn)

Утас: 264136, 266233

---оо---